

Огноо: 2024.09.10

№ 47

Улаанбаатар хот

**“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүнийг түр томилох тухай**

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.11 дэх хэсэг, Авлигатай тэмцэх газрын 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 05/10309 албан тоот, Монголбанкны 2024 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн А-1/506 албан тоотыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцож, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангаж байгаа З.Оюунцацралыг 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн нөхөн сонгууль хүртэлх хугацаанд “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр түр томилсугай.

2. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр түр томилогдсон З.Оюунцацралд Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН